



МОНГОЛ улсын  
**УУГАН**  
ҮЙЛДВЭР

СҮҮ Хууцагт Компани



ГОЛОМТ  
КАПИТАЛ

# СҮҮ БОНД

Үнэт цаасны танилцуулга

2017 он

## Үнэт цаас гаргах үндэслэл

Үнэт цаас гаргагч нь “Компанийн тухай хууль”-ийн 41, 42, 43 дугаар зүйл, 76 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 5, 6, 7 дугаар зүйл болон “Сүү” ХК-ийн дүрмийн 7.1, 7.3 дугаар заалт, “Сүү” ХК-ийн 2017 оны 05 дугаар сарын 01 өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Үнэт цаас гаргагч нь нийт 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17.5 хувийн хүүтэй 60,000 ширхэг “Сүү бонд”-ыг хугацааны эцэст нэрлэсэн үнээр хүүгийн төлбөрийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгөөр олон нийтэд нээлттэй санал болгон гаргаж байна.

## ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч	“Сүү” ХК
Бондын төрөл	Урамшуулалтай бонд
Бондын арилжаа	Нээлттэй хүрээнд
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Нийт тоо, ширхэг	60,000 ширхэг
Нийт үнийн дүн	<b>6,000,000,000 төгрөг</b>
Бондын хугацаа	<b>12 сар</b>
Бондын жилийн хүү	<b>17.5%</b>
Хүү төлөх хугацаа	Хугацааны эцэст нэг удаа
Бондын эргэн төлөлтийн хэлбэр	Хугацааны эцэст нэрлэсэн үнээр
Бондын зарцуулалт	Компанийн хөрөнгийн зах зээлд чиглэсэн бодлогын хүрээнд: (i) эхний ээлжийн шаардлагатай тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт татах, (ii) тогтмол ногдол ашиг тарааж эхлэх болон гадаад зээлийн валютын ханшийн алдагдлыг арилгах зорилгоор зээлийн үлдэгдлийг дотоод эх үүсвэрээр солих
Эргэн төлөлтийн баталгаа	Хувьцаат капиталын 38.7% барьцаа (133,103,000 ширхэг)
LTV	35.10%
Андеррайтер	Голомт Капитал ҮЦК ХХК
Төлбөр, тооцоо	Арилжааны Төлбөр Тооцоо ХХК
Үнэт цаасны хадгаламж	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
Арилжаалах зах зээл	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨРИЙН БИЧИГ ГАРГАЖ БАЙГАА БОЛНО.**

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий өрийн бичгийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Сүү ХК нь энэхүү 6.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийг ам.долларын гадаад зээлийн дахин санхүүжилтэд болон үйлдвэрлэлийн шинэ төрлийн савлагааны шугам нэвтрүүлэх хөрөнгө оруулалтад зарцуулна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

### Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч компани:	“Сүү” ХК
Байгуулагдсан огноо:	1958 он
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
Үнэт цаасны бүртгэл	Монголын Хөрөнгийн Бирж
Хувьцааны символ	SUU
Хувьцааны ангилал	I ангилал
Хувьцааны тоо, ширхэг:	344,000,000
52 долоо хоногийн дээд, доод ханш	122.18-162.9 төгрөг
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг-29, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37
Утас:	+976-70007755
Факс:	+976-77072222
И-мейл:	<a href="mailto:info@mongolmilk.mn">info@mongolmilk.mn</a>
Веб хуудас:	<a href="http://www.mongolmilk.mn">www.mongolmilk.mn</a>

### Үнэт цаас гаргагчийн танилцуулга

Үнэт цаас гаргагч нь их хувьчлалын үеэр 1992 онд төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болж Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэгдсэн ба 2005 онд бүрэн хувьчлагдсан байна. Улмаар Макс Группын удирдлагууд Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авч, менежмент хийснээр компанийн хөгжлийн шинэ шат эхэлсэн гэж үздэг.

Үнэт цаас гаргагч нь 2006 оноос хойш үйлдвэрлэлдээ шинэчлэл хийж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, зах зээлд эзлэх байр суурийг сайжирснаар компанийн нэр хүнд нэмэгдэн, хувьцааны үнэд өсөлт гарч, зах зээлийн үнэлгээ нь нэмэгдсэн байна.

Үнэт цаас гаргагч нь 2016 оны байдлаар 41.6 тэрбум төгрөгний борлуулалтын орлого, 500 сая төгрөгний цэвэр ашигтайгаар ажилласан ба 2013 оноос хойш компанийн үйл ажиллагаа эрчимтэй өсч борлуулалт 24 хувиар нэмэгдсэн бол энэ хугацаанд компанийн нийт хөрөнгө 38 хувиар нэмэгдэж 49 тэрбум төгрөгт хүрээд байна.

2017 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь олон улсын стандартад нийцсэн хамгийн сүүлийн үеийн техник технологийг ашиглан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн 100 орчим нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн улсын хэмжээнд 48%, нийслэлийн хэмжээнд шингэн сүүний 83%-ийн нийлүүлэлтийг дангаараа гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагч нь зах зээлд тэргүүлэгч үндэсний үйлдвэрлэгчийн нийгмийн хариуцлагыг ухамсарлан жил бүр нийгэмд хандсан төсөл, хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлдэг бөгөөд эдгээрээс “Сүүгээр эрүүлжье”, “Ногоон гэрэл-Цагаан шугам”, “Хаврыг өнтэй давъя” гэх мэт хөтөлбөрүүдийг онцолж болох юм.

## Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ, арилжааны идэвх

Үнэт цаас гаргагч нь хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 344,000 ширхэг хувьцааг 1,000 хувааж нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 344,000,000 ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан. Хувьцааг хуваасны дараах хоёрдогч зах зээлийн арилжаа 2016 оны 6 сарын 20-ны өдөр нээгдсэн байна. Мөн тус оны 7 сарын 22-ны өдөр МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу I ангиллын хувьцаа болж бүртгэгджээ.

2016 оны эцсийн байдлаар үнэт цаас гаргагчийн хувьцааны ханш 128.16 байсан бол 2017 оны 5 сарын 31-ний өдрийн байдлаар үнэт цаас гаргагчийн хувьцааны ханш 128.35 төгрөг хүрч ханш харьцангуй тогтвортой байна. Хувьцааны ханшийн 1 жилийн өсөлт -7.0% хувь, 5 жилийн өсөлт 60.4% хувь бол 10 жилийн өсөлт 25,570.0% буюу ханш 257 дахин өсчээ.

### Үнэт цаас гаргагчийн хувьцааны ханш, төгрөгөөр (2007/05-2017/05)




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Хувьцааны ханш өсөхийн хэрээр зах зээлийн үнэлгээ өсөж 2016 оны эцсийн байдлаар 44.1 тэрбум төгрөгт хүрч МХБ-ийн зах зээлийн үнэлгээний 2.99 хувийг бүрдүүлж, МХБ дээр бүртгэлтэй компаниудаас компанийн үнэлгээний хэмжээгээр эхний 6-д орсон байна. 2016 онд Сүү ХК-ийн хувьцаа 2015 онтой харьцуулахад 10.4 тэрбум төгрөгөөр буюу 30.8 хувь өссөн бөгөөд энэ хугацаанд МХБ-ийн ТОП-20 индекс 2.1% унасан байна.

## Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид

### Хувьцаа эзэмшигчид, 2017 он



Үнэт цаас гаргагч нь 2005 онд бүрэн хувьчлагдсан ба 2017 оны 5 дугаар сарын байдлаар олон нийтэд гаргасан нийт хувьцааны дийлэнх олонх буюу 93.81% (322,723,000 ширхэг хувьцаа)-ийг иргэн Д. Жамъян, Д. Ганбаатар, Б. Түвшинтөгс нар эзэмшдэг бол 6.19% буюу 21,277,000 ширхэг хувьцааг бусад жижиг хөрөнгө оруулагч нар эзэмшиж байна.

Эх сурвалж: ҮЦТХТ, Сүү ХК

### Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон худалдаа юм. Үйл ажиллагааны шатлал нь сүүний бэлтгэл буюу сүү татан авалт, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанарын удирдлага, борлуулалт гэсэн хэсгээс бүрдэнэ.

#### Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн дамжлаг




Үнэт цаас гаргагч нь Төв, Сэлэнгэ, Хэнтий, Булган аймгуудад 6 сүү цуглуулах цех, 10 сүүний хөргөлттэй тасаг, 3 сүү боловсруулах үйлдвэртэй үйл ажиллагаа явуулж байна.

### Үйлдвэрлэлийн хэмжээ

2016 онд үнэт цаас гаргагч нь нийт 14 сая литр сүүг татан, 19.5 сая л бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Энэ нь 2015 онтой харьцуулахад 9.8% өссөн үзүүлэлт юм. 2016 онд сүүний үйлдвэрлэл 23%, аарц, ааруул, цөцгийн тосны үйлдвэрлэл 13%, зайрмагны үйлдвэрлэл 53% өссөн бол тараг, йогуртны үйлдвэрлэл 16% буурчээ.

#### Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн хэмжээ, мян. литр



Эх сурвалж: Сүү ХК

## Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

### Орлогын тайлан, сая төгрөг (2013-2016)

	2013	2014	2015	2016
<b>Борлуулалтын орлого</b>	<b>33,509</b>	<b>38,125</b>	<b>37,890</b>	<b>41,642</b>
ББӨ	(22,966)	(26,370)	(27,226)	(30,581)
<b>Нийт ашиг</b>	<b>10,543</b>	<b>11,755</b>	<b>10,664</b>	<b>11,062</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,526)	(3,650)	(4,721)	(5,120)
Борлуулалтын, маркетингийн зардал	(650)	(693)	(1,124)	(818)
Бусад үйл ажиллагааны зардал	(640)	(1,198)	(362)	(346)
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>5,726</b>	<b>6,214</b>	<b>4,456</b>	<b>4,777</b>
Хүүгийн орлого	1	3	33	10
Хүүгийн зардал	(1,427)	(1,567)	(1,854)	(1,750)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(2,138)	(1,741)	(2,304)	(2,332)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>2,163</b>	<b>2,909</b>	<b>331</b>	<b>705</b>
Татварын зардал	(549)	(662)	(208)	(111)
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>1,614</b>	<b>2,247</b>	<b>123</b>	<b>595</b>

### Санхүүгийн байдлын тайлан, сая төгрөг (2013-2016)

	2013	2014	2015	2016
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>17,849</b>	<b>27,644</b>	<b>32,340</b>	<b>12,070</b>
Бэлэн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	584	161	162	209
Дансны ба бусад авлага	7,637	18,438	23,057	2,241
Бараа материал	5,676	8,424	7,362	6,385
Урьдчилж төлсөн зардал	3,952	622	2,258	3,235
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>17,704</b>	<b>16,660</b>	<b>15,762</b>	<b>37,196</b>
Үндсэн хөрөнгө	16,891	16,118	14,554	17,045
Бусад хөрөнгө	813	542	1,208	20,152
<b>Нийт хөрөнгө</b>	<b>35,554</b>	<b>44,303</b>	<b>48,602</b>	<b>49,266</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>8,802</b>	<b>23,545</b>	<b>24,182</b>	<b>16,836</b>
Дансны өглөг	1,530	1,613	4,327	6,557
Богино хугацаат өглөг	7,272	21,931	19,855	10,279
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>10,172</b>	<b>1,931</b>	<b>2,371</b>	<b>9,792</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>18,973</b>	<b>25,476</b>	<b>26,553</b>	<b>26,628</b>
<b>Эздийн өмч</b>	<b>16,581</b>	<b>18,827</b>	<b>22,049</b>	<b>22,638</b>
Хувьцаат капитал	34	34	34	34
Халаасны хувьцаа	(6)	(6)	(6)	(12)
Эздийн өмчийн бусад хэсэг	3,670	3,670	3,670	3,670
Хуримтлагдсан ашиг/алдагдал	12,883	15,130	18,351	18,946
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>35,554</b>	<b>44,303</b>	<b>48,602</b>	<b>49,266</b>

**Мөнгөн гүйлгээний тайлан, сая төгрөг (2013-2016)**


	2013	2014	2015	2016
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
<b>Мөнгөн орлогын дүн</b>	8,270.4	4,768.1	7,706.4	47,399.7
Татварын өмнөх ашиг	2,162.7	2,908.7	331.3	-
Элэгдэл ба амортизаци	1,595.3	1,913.7	1,896.4	-
Гадаад валютын хэрэгжээгүй алдагдал	1,371.3	1,498.9	2,303.9	-
Бусад	3,141.1	(1,553.2)	3,174.8	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	(7,476.5)	428.2	(2,174.8)	(42,181.3)
Орлогын татварын төлөлт	(577.3)	(344.8)	(125.0)	-
Хүүгийн төлөлт	(1,247.2)	(1,562.0)	(1,874.1)	-
Бусад	(5,652.0)	2,334.9	(175.7)	-
<b>Үндсэн ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>793.9</b>	<b>5,196.3</b>	<b>5,531.6</b>	<b>5,218.3</b>
<b>ХО-ын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-	-	-
Мөнгөн орлогын дүн	46.6	81.1	-	0.8
Мөнгөн зарлагын дүн	(4,389.5)	(11,584.4)	(1,595.6)	(0.5)
<b>ХО үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,342.8)</b>	<b>(11,503.3)</b>	<b>(1,595.6)</b>	<b>0.3</b>
<b>Санхүүгийн ҮА-ны мөнгөн гүйлгээ</b>	-	-	-	-
Мөнгөн орлогын дүн	8,610.2	13,379.1	7,215.3	9,541.5
Мөнгөн зарлагын дүн	(4,770.7)	(7,495.0)	(11,135.5)	(14,581.5)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(0.9)	(0.5)	(14.5)	(132.0)
<b>Санхүүгийн ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,838.6</b>	<b>5,883.6</b>	<b>(3,934.7)</b>	<b>(5,172.1)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>289.7</b>	<b>(423.4)</b>	<b>1.3</b>	<b>46.6</b>
<b>Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл</b>	<b>294.5</b>	<b>584.2</b>	<b>160.7</b>	<b>162.1</b>
<b>Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл</b>	<b>584.2</b>	<b>160.7</b>	<b>162.1</b>	<b>208.6</b>

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ**

**Сүү, сүүн бүтээгдэхүүний салбар**

Монгол Улсын хэмжээнд 2015 оны байдлаар нийт сүүний хэрэглээ 909.7 сая литр хүрсэн ба үүний 874.4 сая литр сүүг Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн бол 35.3 сая литрийн хуурайг сүүг импортоор оруулж ирсэн байна. Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн сүүний 4%-ийг буюу 70.3 сая литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү бүрдүүлж байна. Энэ нь сүү, цагаан идээний үйлдвэрлэлд, үндэсний уламжлалт аргаар бэлтгэгдсэн бүтээгдэхүүн зонхилсон хэвээр байгаатай холбоотой юм.

**Монгол улсын нийт сүүний бэлтгэл (2009-2015)**




Эх сурвалж: YCX, Голомт Капитал ҮЦК



2015 оны байдлаар улсын хэмжээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний 50.2 хувь буюу 35.3 сая литр сүүг импортын хуурай сүүнээс хангаж байгаа нь цэвэр сүүний зах зээлд цаашид тэлэх өргөн боломж байгааг илтгэж байна. 2010-2015 онд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү 33.8 сая-с 70.3 сая л болж өссөн ба нийлмэл жилийн дундаж өсөлт (НЖДӨ) +15.8% байна. Үүнтэй харьцуулахад импортын хуурай сүүний сүүний нийлмэл жилийн дундаж өсөлт (НЖДӨ) +4.7% байна. Үр дүнд нь импортын хуурай сүүний эзлэх хувь 2010 онд 83% байсан бол 2015 онд 50% болж буурсан байна.

**Дотоодын үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний мэдээлэл**




Эх сурвалж: УСХ, Голомт Капитал ҮЦК

Улсын хэмжээнд хоногт 230.0 гаруй мянган литр сүү боловсруулах хүчин чадалтай нийт 100 гаруй үйлдвэр, цех байгаагаас Улаанбаатар хотод 45 нь үйлдвэрлэл эрхэлж байна. Эдгээрээс 8-10 нь жилийн турш тогтвортой ажиллаж хүч чадлынхаа 40 хүртэлх хувийг ашиглаж (зайрмагны үйлдвэр оруулсан) байна<sup>1</sup>.

**Дотоодын зах зээлд эзлэх байр суурь**

2016 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн 48%-ийг бүрдүүлж байгаа ба өмнөх онтой харьцуулахад зах зээлд эзлэх байр сууриа 3.6%-р нэмэгдүүлсэн байна. Үүнээс харахад Сүү ХК нь зах зээлд тэргүүлээд зогсохгүй хоёрдогч өрсөлдөгчөөсөө 2 дахин илүү хувийг эзэлж байна.

**Граф 1. Дотоодын нийт сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь**




Эх сурвалж: Сүү ХК


<sup>1</sup>, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам

Үнэт цаас гаргагч нь 2016 онд богино хугацаанд хадгалдаг шингэн сүүний зах зээлд эзлэх байр сууриа өмнөх онтой харьцуулахад 1 орчим хувиар нэмэгдүүлж зах зээлийн 83.2%-ийг буюу 12,496 тн шингэн сүүг үйлдвэрлэн зах зээлийг хангасан байна. Үнэт цаас гаргагч нь Шингэн сүүний зах зээл нь дотоодын сүүний татан авалтад тулгуурласан, богино хугацаанд хадгалдаг зэрэг шинж чанартай тул өрсөлдөгч цөөн юм.

Харин Урт хугацаанд хадгалдаг сүүний зах зээл (тетрапак савлагаатай сүү)-ийн хувьд Монгол улсад 2006 оноос эхлэн үйлдвэрлэл эрчимтэй явагдсан бөгөөд 2016 оны эцсийн байдлаар 38.8% буюу 4,457 тн сүүг АПУ ХК эзэлж байгаа бол 30.6% буюу 3,522 тн сүүг Витафит ХХК үйлдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагч нь 2016 оны 5-р сараас эхлэн шинээр тетрапак сүүний зах зээлд орсон ба 2016 оны эцсийн байдлаар зах зээлийн 7.2%-ийг эзэлж байна.



Шингэн сүүний зах зээлд эзлэх хувь




Тетрапак сүүний зах зээлд эзлэх хувь

Эх сурвалж: Сүү ХК

2016 онд Монгол улсын хэмжээнд нийт 11,016 тн тараг /йогурт ороогүй болно/ үйлдвэрийн аргаар боловсруулагдан худалдаалагдсан ба үүний 45.2% буюу 4,976 тн тарган бүтээгдэхүүнийг Үнэт цаас гаргагч, 24.1% буюу 2,659 тн тарган бүтээгдэхүүнийг Витафит ХХК, 14.6% буюу 1,612 тн бүтээгдэхүүнийг АПУ ХК тус тус нийлүүлсэн байна.

Тарагны зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Сүү ХК


## ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын хүүгийн түвшин болон үндэслэл

Бондын жилийн хүүг банкны хадгаламжийн болон Засгийн газрын үнэт цаасны хүү (“ЗГҮЦ” гэх)-ээс өндөр байхаар тогтоосон. Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, МХБ дээр нээлттэй арилжаалагдаж буй ЗГҮЦ-ны хүү зэргийг харгалзан Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч нарт жилийн 17.5%, татварын дараа цэвэр 15.75%-ийн өгөөж өгөхөөр тогтоосон.

### Засгийн газрын үнэт цаасны хүүгийн муруй


Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагддаг жижиглэнгийн ЗГҮЦ-ны хүүгийн түвшин нь компанийн бондын жишиг хүү болдог. Энэхүү үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үед ЗГҮЦ нь 3, 6, 9, 12, 24, 36 сарын хугацаатай, 13-15%-ийн хүүтэй арилжаалагдаж байгаа ба хүүгийн орлого нь татвараас чөлөөлөгдсөн байдаг. Хамгийн сүүлийн буюу 2017 оны 6 сарын 6-ны 12 сарын хугацаатай ЗГҮЦ-ны хүү нь 13.454% байсан ба энэ нь 42 хоногийн дотор 2.63% буурсан үзүүлэлт юм. Энэхүү ижил хугацаатай ЗГҮЦ-тай харьцуулахад Үнэт цаас гаргагчийн санал болгож буй компанийн бонд 17.5%, татварын дараах өгөөж 15.75%-ийн хүүтэй байгаа нь ЗГҮЦ-наас даруй 2.296%-ийн илүү хүүг татварын дараа хөрөнгө оруулагчдад төлөхөөр байна.



ЗГҮЦ-ны хүү хурдацтай унаж байгаа шалтгааныг 2017 оны 5 сарын 24-ний өдөр батлагдсан ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдэх Монгол улсын төсвийн бодлогын өөрчлөлттэй холбож болох юм. Уг хөтөлбөрийн хүрээнд хувь хүний хадгаламжийн хүүгийн орлогод 10 хувийн татварыг 2017 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн ногдуулахаар шийдвэрлэсэн ба энэ нь ЗГҮЦ-ны эрэлтийг эрс нэмэгдүүлсэн. Тухайлбал, 5 дугаар сард жижиглэнгийн ЗГҮЦ-ны зарлагдсан тоо ширхэг 690,000 ширхэг байсан бол захиалгын хэмжээ 1,055,443 ширхэг буюу 1.5 дахин өндөр байсан байна. Тэр дундаа банкны хадгаламжтай өрсөлдөхүйц 2, 3 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны захиалгын хэмжээ сүүлийн 2 сарын дунджаар 2.97 дахин их байв. Энэ нь зах зээлийн эрэлт өндөр байгааг илэрхийлж байна. Мөн 2017 оны 6 сарын 15-ны өдөр Төв банкны бодлогын хүү 2 хувиар буурч 12% болсон нь ЗГҮЦ-ны хүү, арилжааны банкуудын хадгаламжийн хүү цаашид буурахад нөлөөлөх төлөвтэй байна.

### Банкны хадгаламжийн хүүгийн харьцуулалт

Арилжааны банкнуудын 12 сарын хугацаатай хадгаламжийн дундаж хүү 15 хувьтай байна:



Үүнээс харахад Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын өгөөж нь арилжааны банкнуудын 12 сарын хадгаламжийн хүүгээс 2.5 хувиар өндөр байна.



Компанийн бондтой өрсөлдөхүйц бүтээгдэхүүн болох ЗГҮЦ болон арилжааны банкны хугацаат хадгаламжийн хүүтэй харьцуулахад Сүү бондын санал болгож буй хүү нь даруй 2.3-2.5 хувиар өндөр байна.

## Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг (i) эхний ээлжийн шаардлагатай тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт татах, (ii) тогтмол ногдол ашиг тараах болон гадаад валютын ханшийн алдагдлыг арилгах зорилгоор ам.долларын зээлийн үлдэгдлийг хугацаанаас нь өмнө эргэн төлөхөд зарцуулах юм. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад Андеррайтер болон МХБ хяналт тавина.

### (i) Эхний ээлжийн шаардлагатай тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт татах



Үнэт цаас гаргагч нь бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 26 хувийг буюу 1.4 тэрбум төгрөгийг PET буюу Полиэтилентерефталат савлагааны шугам нэвтрүүлэхэд шаардлагатай 3.2 тэрбум төгрөгийн эхний ээлжийн хөрөнгө оруулалтад зарцуулахаар төлөвлөж байна.

Энэхүү төслийн зорилго нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэглээнд хялбар сав баглаа бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүтээгдэхүүний нэр төрөл, борлуулалтын хэмжээг өсгөж, ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэй нэр төрөл, савлагаа, чанарын хувьд өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх, үнэт цаас гаргагчийн өрсөлдөх чадварыг сайжруулахад оршино.

### **PET савлагааны тухай:**

PET савлагаа нь хуванцар савлагааны нэгэн төрөл ба дэлхийд хамгийн түгээмэл хэрэглэгддэг хуванцар савлагааны нэг юм. PET савлагааг архи, пиво, ус, ундаа, хүнс, гоо сайхан болон гэр ахуйн бараа гэх мэт өргөн хэрэглээний бүтээгдэхүүний савлагаанд ашигладаг байна. 2015 оны эцсийн байдлаар PET савлагааны хэрэглээ 417 тэрбум савд хүрсэн ба 42 хувь нь Ази, Номхон далайн орнуудаас бүрдсэн байна<sup>2</sup>.

### **PET савлагааны давуу тал:**

PET савлагаа нь дараах<sup>3</sup> давуу талуудыг хэрэглэгч болон компанид авчирдаг:

- Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй
- Хэрэглэхэд хялбар
- Хөнгөн: Тээвэрлэлт даах чадвар сайн
- Хадгалах хугацаа харьцангуй урт буюу дунджаар 28 хоног
- Дахин ашиглах боломжтой тул байгальд ээлтэй
- Төрөл бүрийн хэмжээ, дүрстэй савлагаа хийх боломжтой



<sup>2</sup> Asia-Pacific Consolidates its Position as Global Growth Region for PET Bottles, [Euromonitor International](#), 2016

<sup>3</sup> <http://www.petresin.org/faq.asp>

## Санхүүгийн төсөөлөл, төслийн өгөөж:

Үнэт цаас гаргагч нь бондын санхүүжилтээр PET савалгаа нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэглээнд хялбар сав баглаа бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүтээгдэхүүний нэр төрөл, борлуулалтын хэмжээг өсгөж, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх, үнэт цаас гаргагчийн өрсөлдөх чадварыг сайжруулах юм. Уг төслийн хүрээнд нийт 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх ба төслийн өгөөж нь 69% байх тооцоотой байна.

### (ii) Ам.долларын зээлийн үлдэгдлийг хугацаанаас нь өмнө эргэн төлөх

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 5 сарын 31-ний өдрийн №29215 тоот “Зээлийн гэрээ”-ний дагуу IFC, BIO болон Proraso байгууллагуудаас сүүний үйлдвэрийн шинэчлэлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор нийт 6 сая ам.долларын зээлийг, жилийн 6.5%+LIBOR хүүтэйгээр авсан юм. Харин уг зээлийн барьцаа хөрөнгө нь нийт 21 тэрбум төгрөгний үл хөдлөх хөрөнгө, хувьцаат капиталын 93.81% байна.

Үнэт цаас гаргагчийн бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг энэхүү ам.долларын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр болох 1,891,562.0 ам.долларын эргэн төлөлтийг гүйцэтгэхэд зарцуулна.

Дээрх урт хугацаат ам.долларын зээлийг богино хугацаат төгрөгийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлэх шалтгаан нь дараах хүчин зүйлст оршино. Үүнд:

#### 1) Тогтмол ногдол ашиг тарааж эхлэх

Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгэгдсэн цагаасаа хойш ногдол ашиг тарааж байгаагүй ба нийт хөрөнгийн 38.5%-ийг бүрдүүлж буй 18.9 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашгийн тодорхой хэмжээг хувьцаа эзэмшигчиддээ хуваарилах боломжтой ч урт хугацаат ам.долларын зээлийн нөхцөлийн улмаас ногдол ашиг тараах боломжгүй байна. Энэ нь үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлийн чиглэсэн бодлогоос сөрсөн буюу үнэт цаас гаргагчийн хувьцааны эрэлтийг бууруулах, арилжааны идэвхэд сөргөөр нөлөөлөх, компанийн засаглалаа сайжруулах бодлогод сөргөөр нөлөөлж байна.

#### 2) Гадаад валютын ханшийн зөрүүний алдагдлыг бууруулах

2016 оны эцсийн байдлаар үнэт цаас гаргагч нь нийт 2.3 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал хүлээсэн ба энэ нь үнэт цаас гаргагчийн нийт зээлийн 59% нь ам.долларын зээл байгаатай холбоотой юм. 2016 оны 12 сарын 31-ний байдлаар нийт ам.долларын зээлийн 50.24 хувийг 2011 оны 3 сарын 15-ны өдөр IFC, BIO, Proraso байгууллагуудаас авсан 6.0 сая ам.долларын зээлийн үлдэгдэл болох 2,307,631 ам.доллар буюу 5,744,915,906 төгрөгийн зээл бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь энэхүү зээлийг ам.долларын эсрэг төгрөгийн албан ханш 1,245 төгрөг байх үед авч байсан бол төгрөгийн үнэ цэнэ энэ хугацаанд 2 дахин буурч 2016 оны 12 сарын 30-ны байдлаар албан ханш 2,489.52 төгрөг болсон байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанаас бус Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдалтай холбоотойгоор ам.долларын эсрэг төгрөгийн ханш огцом буурсан ба ирээдүйн эрсдэлийг таамаглашгүй тул их хэмжээний ам.долларын зээлийг дотоод эх үүсвэрээр солих нь 2017-2019 онд учирч болзошгүй гадаад валютын ханшийн зөрүүний алдагдлаас ангижрах боломжтой юм.

## Үнэт цаасны барьцаа хөрөнгө

Үнэт цаас гаргагч, Андеррайтер болон хувьцаа эзэмшигчийн хооронд байгуулсан 2017 оны 05 сарын 30-ны өдрийн 17/09 тоот “Барьцааны гурван талт гэрээ” /цаашид “Барьцааны гэрээ” гэх/-ний дагуу Андеррайтер нь бондын барьцаа хөрөнгө болгож үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч иргэн Дагвадорж овогтой Жамъян-ын эзэмшлийн нийт 133,103,000 ширхэг хувьцааг буюу компанийн 38.69 хувийн эзэмшлийг барьцаалсан болно.

### Барьцааны гурван талт гэрээ

Энэхүү Барьцааны гэрээний хүрээнд Андеррайтер нь Барьцаалагч, иргэн Д.Жамъян нь Барьцаалуулагч, Үнэт цаас гаргагч нь Үүрэг гүйцэтгэгчийн үүргийг тус тус гүйцэтгэж байгаа ба энэхүү гэрээг Монгол Улсын “Иргэний хууль”, “Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль” болон холбогдох бусад хууль, дүрэм, журмыг үндэслэн Барьцаалагч болон Үүрэг гүйцэтгэгч нарын хооронд 2017 оны 05 сарын 09 өдөр байгуулсан 17/06 (147) тоот “Санхүүгийн зөвлөх болон Андеррайтерийн үйлчилгээний гэрээ”-ний “Андеррайтерийн үйлчилгээний нэмэлт нөхцөл”-д заасан “хувьцаагаар баталгаажсан бонд”-ын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон Барьцаалуулагч өөрийн хууль ёсны эрхийн дагуу эд хөрөнгөө Барьцаалагчид барьцаалах, Бондын үүргийн гүйцэтгэлийг Үүрэг гүйцэтгэгч хариуцахтай холбогдсон хэлцлийн нөхцөл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон бий болох талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилгоор байгуулсан. Барьцааны гэрээний хугацаа нь Үүрэг гүйцэтгэгч болох Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, Бондын үндсэн төлбөр, Бондын хүү, алданги зэрэг бондын хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл байна.

Барьцааны зүйл болох 133,103,000 ширхэг хувьцаа нь IFC, BIO, Progarco болон хувьцаа эзэмшигч иргэн Д. Жамъян, Д. Ганбаатар, Б. Түвшинтөгс хоорондын байгуулсан 2011 оны 09 сарын 19 өдрийн 29215 тоот “Хувьцаа барьцаалах гэрээ”-ний дагуу барьцаалагдсан байгаа бөгөөд ҮЦТХТ-д бүртгүүлж тусгаарлагдсан байна. Мөн Андеррайтер нь Барьцааны гурван талт гэрээ болон “Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигч Д.Жамъяны дээрх 133,103,000 ширхэг хувьцааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан”-д 2017 оны 06 сарын 07 өдөр бүртгүүлж барьцааны зүйлийн бүртгэлийг баталгаажуулсан.

Үнэт цаас гаргагч нь 2017 оны 5 сарын 25-ны өдөр IFC, BIO, Progarco байгууллагуудаас зээлийн үлдэгдэл болох 1,846,050 ам.долларыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж нээлттэй өрийн бичиг гаргах замаар хугацаанаас өмнө эргэн төлж барьцааны зүйлүүдийг суллах зөвшөөрлийг Зээлийн гэрээний дагуу бичгээр аваад байна. Энэхүү зөвшөөрлийн дагуу бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр зээлийн эргэн төлөлтийг 2017 оны 06 сарын 30 өдрийн дотор хийж барагдуулснаар IFC, BIO, Progarco болон хувьцаа эзэмшигч иргэн Д. Жамъян, Д. Ганбаатар, Б. Түвшинтөгс нарын хооронд байгуулсан 2011 оны 09 сарын 19 өдрийн 29215 тоот “Хувьцаа барьцаалах гэрээ”-ний дагуу барьцаалагдсан хувьцаа нь ҮЦТХТ дэх бүртгэлээс суллагдана. Үүний дараа Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хяналтын багцын хувьцаа эзэмшигч Д.Жамъяны 133,103,000 ширхэг хувьцааг ҮЦТХТ-д өөрийн нэр дээр бүртгүүлж тусгаарлуулснаар барьцааны зүйлийн бүртгэл дуусгавар болно.

Бондын арилжаа болон барьцаа хөрөнгийг суллах, Барьцаалагчийн нэр дор шилжүүлэх үйл ажиллагаа нь дараах байдлаар явагдана.

Энэхүү барьцааны зүйлийн бүртгэлийн үйл ажиллагаа нь дараах хүснэгтийн дагуу явагдана.



- Андеррайтер нь барьцааны хувьцааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан”-д 2017 оны 06 сарын 07 өдөр бүртгүүлж барьцааны зүйлийн бүртгэлийг баталгаажуулсан.
- Бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Үнэт цаас гаргагчийн IFC, BIO, Proparco-гийн ам.долларын зээлийг үлдэгдлийг хугацаанаас нь өмнө төлж, зээлийн барьцаанд байгаа хувьцааг ҮЦТХТ-д бүртгэгдсэн тусгаарлалтаас суллана.
- Андеррайтер нь ам.долларын зээлийн барьцаанаас суллагдсан хувьцааг Барьцааны гурван талт гэрээний дагуу 1 өдрийн дотор барьцаа хувьцааг ҮЦТХТ-д өөрийн нэр дээр барьцаалж барьцаа хөрөнгийг тусгаарлуулна.

### Барьцааны зүйлийн үнэлгээ

Барьцаа хөрөнгийн үнэлгээг 2017 оны 05 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Бирж дээрх хувьцааны ханшийн 6 сарын жигнэсэн дундаж үнээр тогтоосон.

2016 оны 11 сарын 30-ний өдрөөс 2017 оны 05 сарын 31-ний байдлаар, Үнэт цаас гаргагчийн жигнэсэн дундаж ханш 128.44 төгрөг гарав.

Арилжааны дүн (₮)	Арилжаалсан тоо, ширхэг	Жигнэсэн дундаж ханш
133,846,212.94	1,042,080.00	128.44

Үнэт цаасны барьцаа хөрөнгө нь **17,095,935,514.50** төгрөгөөр үнэлэгдэж байгаа ба LTV буюу бондын үнэлгээний нийт барьцаа хөрөнгөд эзлэх хувь нь 35.10% байна.

### Барьцааны эрх хэрэгжүүлэх

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн гэрээ болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Барьцаалагч буюу Андеррайтер нь барьцааны эрхээ хэрэгжүүлэх эрх үүснэ. (Зохих ёсоор биелүүлээгүй гэдэгт Бондын үндсэн төлбөр болон Бондын



хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу цаг хугацаанд нь Бондын хөрөнгө оруулагчдад бүрэн төлж барагдуулаагүй, Бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгийг заасан зориулалтын дагуу ашиглаагүй зэргийг багтааж ойлгоно).

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд энэхүү Гэрээний 2.2-д дурдсан Барьцааны зүйлийг Иргэний хуулийн 158 дугаар зүйлийн 158.4, “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн зургадугаар бүлгийн дагуу үл маргах журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах, нөхөн төлүүлэх эрх Барьцаалагчид үүснэ. Барьцаалагч нь барьцааны шаардлагыг хангахдаа барьцааны зүйлийг худалдан борлуулж хөрөнгө оруулагчдад борлуулсан Бонд болон түүний хүү, алданги, барьцаалагчид учирсан бусад хохирлыг нөхөн төлнө.

Хэрэв ямар нэгэн шалтгаанаар Барьцааны зүйлийг худалдсан үнийн дүн нь хөрөнгө оруулагчдад борлуулсан Бонд болон түүний хүү, алданги, барьцаалагчид учирсан бусад хохирлыг нөхөн төлүүлэхэд хүрэлцэхгүй бол Үүрэг гүйцэтгэгчийн бусад эд хөрөнгөнөөс гаргуулах эрхийг Барьцаалагч эдэлнэ. Талууд тохиролцож бусад хөрөнгөөс гаргуулж чадаагүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

## Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр

### Дунд хугацааны бизнес төлөвлөгөө

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байна.

Үнэт цаас гаргагч нь 2017 оны бизнес төлөвлөгөөг зах зээлд эзлэх хувиа 52% хүртэл өсгөх бодлогыг хэрэгжүүлэхээр баталсан. Тус зорилгын хүрээнд компани, харилцагч, хэрэглэгч, өрсөлдөгч тус бүрт биелүүлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.

#### Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн зорилго, 2017 он

Компани	Харилцагч
<ul style="list-style-type: none"> <li>Сав баглаа боодол, түүхий эд, сэлбэг хэрэгслийн үнэ, өртөгт хэмнэлт гаргах</li> <li>Ашгийн төвшнийг тогтоосон хэмжээнээс дээгүүр барих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бэлтгэлийн сүүний хэмжээг 14,5 сая литр хүргэх</li> <li>Фермерүүдтэй ахисан түвшинд хамтран ажиллаж, сүү бэлтгэлийн зардлыг бууруулах</li> </ul>
Хэрэглэгч	Өрсөлдөгч
<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулснаар 82%-д хүргэнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувиа 52% хүртэл өсгөх</li> </ul>

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны маркетингийн болон санхүүгийн төлөвлөгөө, үнэлгээчийн хийсэн судалгаа, дэвшүүлсэн төсөөлөл, таамаглалуудад үндэслэн орлогын болон мөнгөн гүйлгээний төсөөлөл гаргав.

**Орлого, цэвэр ашгийн төсөөлөл**

Сая төгрөг	12/31/2015	12/31/2016	6/30/2017(f)	12/31/2017(f)	6/30/2018(f)	12/31/2018(f)
Борлуулалтын орлого	39,069	41,775	26,309	49,626	28,326	53,431
Борлуулсан барааны өртөг	27,226	30,581	18,761	35,299	19,326	37,342
<b>Нийт ашиг</b>	<b>11,843</b>	<b>11,195</b>	<b>7,547</b>	<b>14,327</b>	<b>9,000</b>	<b>16,089</b>
Үйл ажиллагааны зардал	5,456	5,397	4,605	8,231	3,710	6,969
Цалин	2,949	2,721	1,804	3,403	1,943	3,665
Маркетинг	1,124	818	479	843	614	1,158
Засвар үйлчилгээ	122	45	1,396	2,171	30	57
Албан томилолт	109	99	81	120	51	95
Түлш	-	202	410	825	113	213
Түрээс	36	57	42	80	42	80
Бусад	1,115	1,455	392	790	917	1,700
<b>Хүү, татвар, элэгдлийн өмнөх ашиг</b>	<b>6,387</b>	<b>5,798</b>	<b>2,943</b>	<b>6,096</b>	<b>5,289</b>	<b>9,091</b>
Элэгдлийн зардал	390	541	340	676	371	737
Хүү, татварын өмнөх ашиг	5,997	5,257	2,602	5,421	4,919	8,354
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	(3,812)	(2,801)	(52)	(52)		
Хүүгийн зардал	1,854	1,750	1,112	2,093	1,873	2,419
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>331</b>	<b>705</b>	<b>1,438</b>	<b>3,276</b>	<b>3,045</b>	<b>5,936</b>
Татварын зардал	208	111	144	328	761	1,050
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>123</b>	<b>595</b>	<b>1,295</b>	<b>2,948</b>	<b>2,284</b>	<b>4,885</b>

**Мөнгөн гүйлгээний төсөөлөл**

Сая төгрөг	2016A	Q1 (A)	Q2 (f)	Q3 (f)	Q4 (f)	2017(f)	Q1 (f)	Q2 (f)	Q3 (f)	Q4 (f)	2018(f)
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,261	3,181	366	1,183	1,434	6,163	2,720	1,542	1,961	2,361	8,583
Үйл ажиллагааны мөнгөн орлого	47,442	13,101	14,345	11,146	13,564	52,156	14,108	15,447	12,003	14,607	56,165
Борлуулалтын болон бусад орлого	47,442	13,101	14,345	11,146	13,564	52,156	14,108	15,447	12,003	14,607	56,165
Үйл ажиллагааны мөнгөн зардал	42,181	9,920	13,979	9,963	12,130	45,992	11,388	13,905	10,042	12,246	47,582
Бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр	34,546	8,267	10,494	7,329	9,209	35,299	8,902	10,423	8,099	9,917	37,342
Үйл ажиллагааны зардалд төлсөн мөнгө		1,006	2,698	2,150	2,377	8,231	1,751	1,917	1,489	1,812	6,969
Үйл ажиллагааны бусад зардал		24	28	-	-	52	-	-	-	-	-
Татвар, хураамжид төлсөн мөнгө	1,178	90	179	24	24	318	275	152	193	232	853
Санхүүжилтын төлбөрт төлсөн	1,786	533	579	460	521	2,093	460	1,413	260	285	2,419
<b>ХО-ын ү/а мөнгөн гүйлгээ</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>(3,187)</b>	<b>-</b>	<b>(3,187)</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ХО-ын ү/а мөнгөн орлого</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ХО-ын ү/а мөнгөн зардал</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3,187</b>	<b>-</b>	<b>3,187</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн ү/а мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,173)</b>	<b>(3,205)</b>	<b>1,055</b>	<b>2,748</b>	<b>4,612</b>	<b>5,210</b>	<b>(3,367)</b>	<b>(6,061)</b>	<b>10</b>	<b>1,378</b>	<b>(8,040)</b>
<b>Санхүүгийн ү/а мөнгөн орлого</b>	<b>9,542</b>	<b>-</b>	<b>7,773</b>	<b>6,146</b>	<b>14,650</b>	<b>28,568</b>	<b>-</b>	<b>3,240</b>	<b>3,160</b>	<b>3,240</b>	<b>9,640</b>
Богино хугацаат зээл	9,535	-	1,552	2,192	10,403	14,147	-	3,240	3,160	3,240	9,640
Бонд		-	6,000	-	-	6,000					-
Урт хугацаат зээл			-	3,590	4,000	7,590					-
Бусад	7	-	221	364	247	831					-
<b>Санхүүгийн ү/а мөнгөн зардал</b>	<b>14,714</b>	<b>3,205</b>	<b>6,718</b>	<b>3,398</b>	<b>10,038</b>	<b>23,358</b>	<b>3,367</b>	<b>9,301</b>	<b>3,150</b>	<b>1,862</b>	<b>17,680</b>
Богино хугацаат зээл		1,626	1,503	1,737	8,063	12,930	2,301	2,272	2,202	913	7,688
Бонд		-	-	-	-	-		6,000			6,000
Урт хугацаат зээл	14,714	1,771	5,154	1,660	1,975	10,559	1,066	1,028	949	949	3,992
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>89</b>	<b>(24)</b>	<b>1,421</b>	<b>744</b>	<b>6,046</b>	<b>8,187</b>	<b>(647)</b>	<b>(4,519)</b>	<b>1,970</b>	<b>3,739</b>	<b>543</b>
Эхний үлдэгдэл	120	209	185	1,605	2,350	209	8,396	7,748	3,230	5,200	8,396
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>209</b>	<b>185</b>	<b>1,605</b>	<b>2,350</b>	<b>8,396</b>	<b>8,396</b>	<b>7,748</b>	<b>3,230</b>	<b>5,200</b>	<b>8,939</b>	<b>8,939</b>

Дээрх тооцооллоос дүгнэхэд, үнэт цаас гаргагч нь 2018 оны II улирлын байдлаар буюу бондын эргэн төлөлт хийгдсэний дараа нийт 3.2 тэрбум төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байна. Тодруулбал, 2018 оны эцсийн байдлаар нийт 8.9 тэрбум төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байхаар тооцоолов.

**Санхүү байдлын төсөөлөл**


<i>Сая төгрөг</i>	<b>12/31/2016</b>	<b>12/31/2017(f)</b>	<b>12/31/2018(f)</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>12,070</b>	<b>17,445</b>	<b>15,608</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	209	8,396	8,939
Дансны ба бусад авлага	3,199	2,914	180
Бараа материал	6,385	6,135	6,490
Урьдчилж төлсөн зардал	2,277	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>37,196</b>	<b>39,609</b>	<b>38,872</b>
Үндсэн хөрөнгө	26,797	29,885	29,885
Хуримтлагдсан элэгдэл	(9,754)	(10,429)	(11,166)
Биет бус хөрөнгө	79	79	79
Хуримтлагдсан элэгдэл	(78)	(78)	(79)
Бусад хөрөнгө оруулалт	20,152	20,152	20,152
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>49,266</b>	<b>57,053</b>	<b>54,480</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
Богино хугацаат өр төлбөр	16,836	24,643	21,177
Дансны ба бусад өглөг	6,880	6,639	7,222
Богино хугацаат зээл	9,956	18,004	13,955
Урт хугацаат өр төлбөр	9,792	6,823	2,832
Урт хугацаат зээл	9,792	6,823	2,832
<b>Нийт өр төлбөр</b>	<b>26,628</b>	<b>31,467</b>	<b>24,009</b>
<b>Эздийн өмч</b>	<b>22,638</b>	<b>25,586</b>	<b>30,471</b>
Хувьцаат капитал	34	34	34
Халаасны хувьцаа	(12)	(12)	(12)
Эздийн өмчийн бусад хэсэг	3,670	3,670	3,670
Хуримтлагдсан ашиг	18,946	21,894	26,779
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>49,266</b>	<b>57,053</b>	<b>54,480</b>

### Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах

Бондын анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан “Арилжааны журам”-ын дагуу явагдана.

Олон нийтэд санал болгож буй 60,000 ширхэг бондын захиалгыг 14 хоногийн турш авах ба 2017 оны 06 сарын 29-ний өдөр арилжааг хаахаар төлөвлөж байна.


### Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц



- |                                  |   |
|----------------------------------|---|
| 1. Бүртгүүлэх                    | - МБХ болон СЗХ-с зөвшөөрөл гарч бүртгүүлэх |
| 2. Roadshow/нийтэд мэдээллэх аян | - Бүртгүүлсэн өдрөөс 7 хоногийн дотор       |
| 3. Захиалга авах/Book building   | - Бүртгүүлсэн өдрөөс 14 хоногийн дотор      |
| 4. Арилжаа                       | - Бүртгүүлсэн өдрөөс 14 хоногийн дараа      |
| 5. Төлбөр тооцоо                 | - Арилжааны өдрөөс T+0 горимоор             |

### Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн график

Үнэт цаас гаргагч нь арилжаа явагдсанаас 52 долоо хоног буюу 365 хоногийн дараа бондын үндсэн төлбөрийг хүүгийн хамт хөрөнгө оруулагчдад эргэн төлнө.



Бондыг анхдагч зах зээлд байршуулснаас хойш ажлын 15 хоног дотор анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлсэн тухай тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.

### Бондын эргэн төлөлтийн бодолт

Хөрөнгө оруулагч нь бондын үндсэн төлбөрийг хугацааны эцэст нэрлэсэн үнээр нь эргүүлэн авна.

Үндсэн төлбөр = нэрлэсэн үнэ \* худалдан авсан тоо хэмжээ

Хүүгийн хэмжээ = Худалдан авсан бондын тоо \* Нэрлэсэн үнэ \* Бондын хүү

Бондын эргэн төлөлтийн бодолт	
Бондын тоо, ширхэг	1 ш
Эргэн төлөгдөх хугацаа	Худалдаж авсан өдөр + 365 хоног
Хүүгийн төлбөр /татварын өмнөх/	1 ш *100,000 төг *17.5%= 17,500 төг
Хүүгийн төлбөр /татварын дараах/	1 ш *100,000 төг *15.75%= 15,750 төг
Үндсэн төлбөр	1 ш *100,000 төг =100,000 төг
Нийт эргүүлэн авах дүн /татварын өмнөх/	117,500 төг
<b>Нийт эргүүлэн авах дүн /татварын дараах/</b>	<b>115,750 төг</b>

### Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар

Хөрөнгө оруулагч нар бондын анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

<p><b>1 Арилжааны данс нээлгэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүссэн ҮЦК дээр арилжааны данс нээлгэх;</li> <li>- ҮЦК нь ҮЦТХТ болон Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээр харилцагчийн дансыг нээлгэнэ.</li> </ul>	<p><b>2 Мөнгөө байршуулах</b></p> <p>Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээрх өөрийн нэр дээрх 0120 0000 •••• тоот дансанд мөнгөө байршуулна.</p>	<p><b>3 Захиалга өгөх</b></p> <p>Өөрийн ҮЦК-д үнэт цаас худалдан авах захиалга өгнө.</p>	<p><b>4 Арилжаа хаагдах</b></p> <p>Анхдагч зах зээлийн арилжаа хаагдсан өдөртөө үнэт цаас харилцагчийн нэр дээр шилжинэ.</p>
---	--	--	--

### Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

- Өрийн бичиг эзэмшигч нь дараах бичиг, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй. Үүнд:
  - 1.1 Компанийн санхүүгийн тайлантай танилцах,
  - 1.2 Өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээг хүлээн авах,
  - 1.3 Өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн арилжааны саналыг хүлээн авах,
  - 1.4 Хуульд заасан бусад.
- Өрийн бичиг эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй Өрийн бичгийг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах.
- Хугацааны эцэст Өрийн бичгийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах, эсвэл хугацааны эцэст Өрийн бичгийн баталгаа гаргагчийг Өрийн бичгийн эргэн төлөлтийг хийхийг шаардах болон Монгол улсын хуульд заасан бусад холбогдох хууль, журамд заасан эрхүүдийг эдэлнэ.

## Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

1. Өрийн бичгийн нэрлэсэн үнээр хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас буцаан худалдаж авах, хуримтлагдсан хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах.
2. Өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэл хүргэх.
3. Өрийн бичиг борлуулснаас олсон орлогыг зөвхөн Андеррайтерын гэрээ, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зорилтын дагуу зарцуулах.
4. Өрийн бичгийн үүрэг гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Үнэт цаасны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч Үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах.
5. Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар төлж барагдуулах үүрэгтэй.
6. Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг Голомт Банк дээр өөрийн эскроу данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө шилжүүлнэ.
7. Шилжүүлсэн дүнг Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээрх хөрөнгө оруулагчийн данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна.

## Татвар

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4 дүгээр заалт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1.4 дүгээр заалтын дагуу хүүгийн орлого нь албан татвар ногдох орлого юм. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19.1.4 болон 23.1 дүгээр заалтуудын дагуу хүүгийн орлогын дүнгээр нь тооцож 10 хувийн татвар ногдуулна. Иймд хөрөнгө оруулагч хувь хүн нь бондын хүүгийн орлогоос 10 хувийн албан татвар төлөх бөгөөд энэхүү бондыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид очих татварын дараах өгөөж 15.75% байхаар тооцоологдож байна. Аж ахуйн нэгжийн хувьд хүүгийн орлогыг өөрөө мэдүүлнэ.

Бондын хугацааны туршид хөрөнгө оруулагч нь бондоо хоёрдогч зах зээл дээр худалдах тохиолдолд худалдаж буй үнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн уг бондыг худалдаж авсан үнэ болон тухайн хугацаанд хуримтлагдсан хүү, холбогдох арилжаанд оролцоход гарсан зардлуудын нийлбэрээс илүү гарсан тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухайн хуулийн 8, 20 дугаар зүйлд зааснаар хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар төлөх ба энэ нь мөн 10 хувь байна.

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт
ААН	Аж ахуйн нэгж
АТТ	Арилжааны Төлбөр Тооцоо ХХК
ББӨ	Борлуулсан барааны өртөг
БДК	Брокер, дилерийн компани
Бонд	ҮЦЗЗТХ-ийн 4.1.9-д заасан “өрийн хэрэгслийг”
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЖДӨ	Нийлмэл жилийн дундаж өсөлт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
СЗХ	Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хороо
Төгрөг (₮)	Монгол улсын мөнгөн тэмдэгт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБ	Улаанбаатар хот
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
ҮЦК	Үнэт цаасны компани
ХК	Хувьцаат Компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
IFC	International Financial Corporation
BIO	Belgian Investment Company for Developing Countries SA
Proparco	Society De Promotion et de Participation pour la Cooperation Economique
LIBOR	London Interbank Offered Rate (Лондонгийн Банк Хоорондын Зах Зээлийн Хүү)

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

### АНДЕРРАЙТЕР:



<b>Компанийн нэр:</b>	Голомт Капитал ҮЦК ХХК
<b>Регистрийн дугаар:</b>	5481589
<b>Хаяг:</b>	401 тоот, Ди Би Билдинг, Олимпын гудамж 12/1, Улаанбаатар 210464, Монгол
<b>Утас:</b>	+976-70121530
<b>И-мэйл:</b>	info@golomtcapital.com

### АУДИТОР:



<b>Компанийн нэр:</b>	Дөлгөөнхайрхан уул аудит ХХК
<b>Регистрийн дугаар:</b>	5284309
<b>Хаяг:</b>	УБ хот, БЗД, 13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 46-401 тоот
<b>Утас:</b>	99055711
<b>И-мэйл:</b>	dulguunhairhan_audit@mongol.net

### ХУУЛЬ:



<b>Компанийн нэр:</b>	Өмгөөллийн Ананд Адвокаты ХХН
<b>Регистрийн дугаар:</b>	5795958
<b>Хаяг:</b>	УБ хот, СБД, Метробизнес, В-1003 тоот
<b>Утас:</b>	329441, 70119442
<b>И-мэйл:</b>	enkhtsetseg@anand-advocates.mn

### ҮНЭЛГЭЭ:



<b>Компанийн нэр:</b>	Файн Эстимэйт ХХК
<b>Регистрийн дугаар:</b>	5353459
<b>Хаяг:</b>	УБ хот, СБД, 6-р хороо, Бага тойруу, 8-14 тоот
<b>Утас:</b>	99094391
<b>И-мэйл:</b>	halo_tsoomoo@yahoo.com

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР (БОРЛУУЛАЛТ):



<b>Компанийн нэр:</b>	Ард Капитал Групп ҮЦК ХХК
<b>Холбоо барих:</b>	+ 976-11310262; info@ardcapital.mn

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР (БОРЛУУЛАЛТ):



<b>Компанийн нэр:</b>	Тэнгэр Капитал ҮЦК ХХК
<b>Холбоо барих:</b>	+ 976-70110637; info@tengercapital.com